



“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 1


Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.8 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалт, “Багануур” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Багануур” ХК нь 2022 оны санхүүгийн жилд алдагдалтай ажилласан тул 2022 оны санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Компанийн 2022 оны санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
3. Ногдол ашиг хуваарилахтай холбоотой шийдвэр гаргуулах асуудлыг хуулийн хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж байхыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА



Б.ЦЭВЭГЖАВ